

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/083/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.17	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: О.Батжаргал	
	Утас: 99329595	Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn
	Ахлах аудитор	М.Алтантуяа
	Утас: 99061861	Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Б.Азбаяр
Утас: 99061429	Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn	
	Цахим хуудас: www.audit.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
Өмнөх 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.17 № 99
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусвар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 97 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

622502048

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>337,347,160.11</u>	<u>252,095,713.09</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	271,140,571.00	179,280,893.98
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	271,140,571.00	179,280,893.98
3121	Төгрөг	271,140,571.00	179,280,893.98
31211	Төрийн сангийн харилцах	271,140,571.00	179,280,893.98
35	БАРАА МАТЕРИАЛ	66,206,589.11	72,814,819.11
351	Түүхий эд материал	2,099,000.00	2,345,120.00
35130	Эм боох материал	2,099,000.00	2,345,120.00
354	Хангамжийн материал	64,107,589.11	70,469,699.11
35410	Бичиг хэргийн материал	15,444,301.00	17,814,041.00
35420	Аж ахуйн материал	46,626,988.11	51,814,658.11
35450	Барилгын засварын материал	2,036,300.00	841,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,380,836,147.43</u>	<u>1,426,390,747.87</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,380,836,147.43	1,426,390,747.87
392	Биет хөрөнгө	1,172,361,147.43	1,217,561,303.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	966,092,361.00	966,092,361.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(124,118,931.33)	(152,967,786.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	306,976,095.12	464,197,937.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(110,035,901.15)	(176,691,485.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,090,211.04	106,300,987.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,253,627.48)	(55,414,591.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,041,500.00	37,041,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,027,984.80)	(19,233,581.76)
39217	Ном	44,597,425.03	48,235,963.03
393	Биет бус хөрөнгө	208,475,000.00	208,829,444.46
39301	Програм хангамж	770,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(85,555.54)
39303	Бусад биет бус хөрөнгө	208,475,000.00	208,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,718,183,307.54</u>	<u>1,678,486,460.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>47,366,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	47,366,000.00
413	Өглөг	-	47,366,000.00
4136	Бусад өглөг	-	47,366,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	47,366,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,718,183,307.54</u>	<u>1,631,120,460.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,718,183,307.54	1,631,120,460.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	462,571,101.29	462,571,101.29
51101	Өмч: - төрийн	462,571,101.29	462,571,101.29

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн		
51210	Өмнөх үеийн үр дүн	765,346,224.52	678,283,377.94
51220	Тайлант үеийн үр дүн	765,346,224.52	765,346,224.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	(87,062,846.58)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	490,265,981.73	490,265,981.73
		1,718,183,307.54	1,678,486,460.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,670,807,100.00	2,097,693,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,861,600.00	1,187,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,861,600.00	1,187,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,861,600.00	1,187,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,861,600.00	187,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	1,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,664,945,500.00	2,096,505,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,526,864,000.00	1,948,134,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,526,864,000.00	1,948,134,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	138,081,500.00	148,371,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,657,942,255.50	2,291,270,984.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,657,942,255.50	2,291,270,984.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,555,818,935.50	2,181,690,115.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,102,510,205.00	1,574,356,997.00
210101	Үндсэн цалин	743,650,869.00	1,038,235,684.00
210102	Нэмэгдэл	306,985,474.00	480,671,813.00
210104	Урамшуулал	51,873,862.00	55,449,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,396,538.00	196,269,879.98
210201	Тэтгэврийн даатгал	95,185,401.71	134,945,976.82
210202	Тэтгэмжийн даатгал	11,206,602.05	15,832,516.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,864,081.67	8,187,024.96
210204	Ажилгүйдлийн даатгал	2,103,065.21	7,444,016.05
210205	Эрүүл мэндийн даатгал	21,037,387.36	29,860,345.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,896,880.00	141,155,331.37
210301	Гэрэл, цахилгаан	6,255,856.00	6,314,713.37
210302	Түлш, халаалт	101,882,880.00	112,071,168.00
210303	Цэвэр, бохир ус	22,758,144.00	22,769,450.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,274,260.00	16,999,247.00
210401	Бичиг хэрэг	2,659,180.00	3,349,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,481,720.00	2,691,507.00
210404	Ном, хэвлэл	63,000.00	-

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	725,500.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,344,860.00	9,758,630.00
2105	Нормативт зардал	1,496,810.00	149,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,301,810.00	149,130.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	195,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,656,201.00	7,195,300.00
210604	Урсгал засвар	6,656,201.00	7,195,300.00
2107	Томилолт, зочны зардал	920,000.00	628,000.00
210702	Дотоод албан томилолт	920,000.00	628,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,016,600.00	23,060,509.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,861,600.00	187,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,355,000.00	22,872,909.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,651,441.50	221,875,721.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,356,650.00	79,571,574.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,258,785.00	16,048,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,036,006.50	126,255,347.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,123,320.00	109,580,868.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,938,700.00	107,365,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,041,000.00	95,869,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,897,700.00	11,495,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,184,620.00	2,215,868.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,184,620.00	2,215,868.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,864,844.50	(193,577,984.58)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,864,844.50	(193,577,984.58)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,670,807,100.00	2,097,693,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,861,600.00	1,187,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,861,600.00	1,187,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,861,600.00	1,187,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,861,600.00	187,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,664,945,500.00	2,096,505,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,526,864,000.00	1,948,134,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,526,864,000.00	1,948,134,200.00

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	138,081,500.00	148,371,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	138,081,500.00	148,371,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,554,463,243.00	2,124,257,867.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,554,463,243.00	2,124,257,867.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,452,339,923.00	2,014,676,998.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,102,510,205.00	1,574,356,997.00
210101	Үндсэн цалин	743,650,869.00	1,038,235,684.00
210102	Нэмэгдэл	306,985,474.00	480,671,813.00
210104	Урамшуулал	51,873,862.00	55,449,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,396,538.00	196,269,879.98
210201	Тэтгэврийн даатгал	95,185,401.71	134,945,976.82
210202	Тэтгэмжийн даатгал	11,206,602.05	15,832,516.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,864,081.67	8,032,449.08
210204	Ажилгүйдлийн даатгал	2,103,065.21	7,598,591.93
210205	Эрүүл мэндийн даатгал	21,037,387.36	29,860,345.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	130,896,880.00	141,155,331.37
210301	Гэрэл, цахилгаан	6,255,856.00	6,314,713.37
210302	Түлш, халаалт	101,882,880.00	112,071,168.00
210303	Цэвэр, бохир ус	22,758,144.00	22,769,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,216,600.00	27,913,509.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,861,600.00	187,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,355,000.00	27,725,909.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,319,700.00	69,981,281.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,130,000.00	48,758,781.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,189,700.00	21,222,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,123,320.00	109,580,868.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,938,700.00	107,365,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,041,000.00	95,869,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,897,700.00	11,495,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,184,620.00	2,215,868.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,184,620.00	2,215,868.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	116,343,857.00	(26,564,867.02)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	46,691,800.00	65,294,810.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,691,800.00	65,294,810.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,691,800.00	65,294,810.00

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,691,800.00	65,294,810.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(46,691,800.00)	(65,294,810.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	69,652,057.00	(91,859,677.02)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	201,488,514.00	271,140,571.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	271,140,571.00	179,280,893.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	765,346,224.52	0.00	1,718,183,307.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	765,346,224.52	0.00	1,718,183,307.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	765,346,224.52	0.00	1,718,183,307.54
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	765,346,224.52	0.00	1,718,183,307.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	765,346,224.52	0.00	1,718,183,307.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-87,062,846.58	0.00	-87,062,846.58
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	678,283,377.94	0.00	1,631,120,460.96

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,373,541,000.00	2,187,336,808.39	(186,204,191.61)	92.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,373,541,000.00	2,187,336,808.39	(186,204,191.61)	92.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,256,079,600.00	2,079,971,808.39	(176,107,791.61)	92.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,706,320,700.00	1,574,356,997.00	(131,963,703.00)	92.3
210101	Үндсэн цалин	1,147,313,000.00	1,038,235,684.00	(109,077,316.00)	90.5
210102	Нэмэгдэл	501,947,900.00	480,671,813.00	(21,276,087.00)	95.8
210104	Урамшуулал	57,059,800.00	55,449,500.00	(1,610,300.00)	97.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	213,290,000.00	196,269,879.98	(17,020,120.02)	92.0
210201	Тэтгэврийн даатгал	145,037,200.00	134,945,976.82	(10,091,223.18)	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	17,063,200.00	15,832,516.81	(1,230,683.19)	92.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,531,600.00	8,032,449.08	(499,150.92)	94.1
210204	Ажилгүйдлийн даатгал	8,531,600.00	7,598,591.93	(933,008.07)	89.1
210205	Эрүүл мэндийн даатгал	34,126,400.00	29,860,345.34	(4,266,054.66)	87.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,371,200.00	141,155,331.37	(2,215,868.63)	98.5
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	6,314,713.37	(1,685,286.63)	78.9
210302	Түлш, халаалт	112,071,200.00	112,071,168.00	(32.00)	100.0
210303	Цэвэр, бохир ус	23,300,000.00	22,769,450.00	(530,550.00)	97.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,795,600.00	43,839,309.04	(9,956,290.96)	81.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	187,600.00	(4,812,400.00)	3.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	48,795,600.00	43,651,709.04	(5,143,890.96)	89.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,302,100.00	119,350,291.00	(14,951,809.00)	88.9

**Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,079,600.00	98,127,791.00	(14,951,809.00)	86.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,222,500.00	21,222,500.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,461,400.00	107,365,000.00	(10,096,400.00)	91.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	117,461,400.00	107,365,000.00	(10,096,400.00)	91.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	105,965,900.00	95,869,500.00	(10,096,400.00)	90.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,495,500.00	11,495,500.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	271,140,571.00	271,140,571.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	179,280,893.98	179,280,893.98	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	75.00	66.00	(9.00)	88.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	59.00	57.00	(2.00)	96.6
620003	Үйлчлэх ажилтан	15.00	8.00	(7.00)	53.3
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	948.00	945.00	(3.00)	99.7
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	948.00	945.00	(3.00)	99.7
630001	Төрийн өмчит ЕБС	948.00	945.00	(3.00)	99.7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	75.00	66.00	(9.00)	88.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	54.00	53.00	(1.00)	98.1
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	11.00	(8.00)	57.9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
Байхгүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейко сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэдлэг чадварын ахиц, амжилт, багш бүрийг чадваржуулна.
- Сахилга бат, дэг журам, эмх цэгцийг эрхэмлэн
- Ээлжит хичээлийн жилээр хүүхэд бүрийн авьяасыг нээж чадваржуулна.
- Хүүхэд бүрийн сайн талыг магтан дэмжинэ.

Сургуулийн захирлын 2022 оны А/01 тоот тушаалаар бүтэц орон тоог баталсан бөгөөд нийт орон тоог 75 байхаар баталсан бөгөөд гүйцэтгэлээр 65 багш ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан

“Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,696.8 мянган төгрөг буюу 2.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	337,347.2	252,095.7	(85,251.4)
Мөнгөн хөрөнгө	271,140.6	179,280.9	(91,859.7)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	66,206.6	72,814.8	6,608.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,380,836.1	1,426,390.7	45,554.6
Үндсэн хөрөнгө	1,677,042.6	1,830,783.7	153,741.2
Хуримтлагдсан элэгдэл	(296,206.4)	(404,393.0)	(108,186.6)
Нийт хөрөнгө	1,718,183.3	1,678,486.5	(39,696.8)
Өр төлбөр	-	47,366.0	47,366.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,718,183.3	1,631,120.5	(87,062.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,718,183.3	1,678,486.5	(39,696.8)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 179,280.9 мянган болж өмнөх оноос 91,859.7 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвөөр 1,948,134.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, сурах бичгийн үнэ 187.6 мянга, тендерийн бичиг баримтад 35.0 мянга, түрээсийн орлого 965.0 мянган төгрөг төвлөрч үйл ажиллагааны зардалд 2,041,181.5 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Тайлант оны эхэнд авлагын үлдэгдэлгүй байсан бөгөөд шинээр нэмж авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72,814.8 мянган төгрөг болж 6,608.2 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын данс 6,187.7 мянга, Бичиг хэргийн материал 2,369.7 мянган төгрөгөөр өсөж барилгын засварын материал 1,195.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Төсвийн худалдан авалтаар 144,928.8 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 138,320.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,830,783.7 мянган төгрөг болж 153,741.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 65,294.8 мянга, Боловсролын ерөнхий газраас 23 ширхэг зөөврийн компьютер, 2 ухаалаг телевиз, Баянхонгор сумын ЗДТГ-аас спорт залны гэрэлтүүлгийг 5,000.0 мянган төгрөгөөр Мексим Консалтинг ХХК-аас 47,366.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 18,068.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,631,120.5 мянган төгрөг болж 87,062.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,823,083.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,971,454.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 402,086.2 мянган төгрөгөөр нэмж 2,373,541.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 2,373,241.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,187,336.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,187,336.8 мянган төгрөг буюу 92,2 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшил 109,077.3 мянга, ЭМНДШ 17,020.1 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 2,215.9 мянга, БГАҮ-ний төлбөр 9,956.3 мянга, Бараа үйлчилгээний бусад зардал 14,951.9 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	5,305,700.00	5,305,700.00	0.00	100.00
80233	Хүүхэд хамгаалал	5,442,000.00	5,442,000.00	0.00	100.00
80312	Сургалт семинар	3,744,400.00	3,744,400.00	0.00	100.00
81605	Эрүүл мэндийг дэмжих	5,305,700.00	5,305,700.00	0.00	100.00
81801	үдийн цай хөтөлбөр	105,965,900.00	95,869,500.00	-10,096,400.00	90.47
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	41,301,000.00	41,301,000.00	0.00	100.00
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	15,916,900.00	15,898,000.00	-18,900.00	99.88
81834	Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	1,947,649,300.00	1,784,897,466.58	-162,751,833.42	91.64
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	79,494,500.00	77,884,200.00	-1,610,300.00	97.97
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

81848	Сурах бичгийн тїрээс	5,000,000.00	187,600.00	-4,812,400.00	3.75
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	9,044,400.00	4,345,910.44	-4,698,489.56	48.05
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	148,371,200.00	146,155,331.37	-2,215,868.63	98.51
	НИЙТ	2,373,541,000.00	2,187,336,808.39	-186,204,191.61	92.16

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагад нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Үдийн хоол нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулж “Дүүрэн гэгээ” ХХК-тай 91,891.8 мянган төгрөгөөр Үдийн хоол” нийлүүлэх гэрээг байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого сейко сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-нд ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 2,373,541.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,735.4 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 15,428.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллагад байр ашиглалтай холбоотой зардал байхгүй бөгөөд гар утасны зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээнээс 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь материаллаг хэмжээнд тооцохгүй тул зөрчлөөр аваагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сургуулийн захирлын 2024.07.03-ны өдрийн “Нягтлан бодогчид урамшуулал олгох тухай” Б/44 дүгээр тушаалаар нягтлан бодогчид балансын урамшуулалд 3 сарын үндсэн цалин буюу 4,413.0 мянган төгрөг олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

5.1 Албан шаардлага

5.1.1. Боловсрол шинжлэх ухааны газрын 2024.07.09-ний өдрийн Б/42 “Урамшуулал олгох тухай” А/42 дугаар тушаалаар “Өөрчлөлтгүй” дүгнэгдсэн Төсвийн шууд захирагч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох шийдвэрийн дагуу 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагчид балансын урамшуулал олгодог байдлыг таслан зогсоож цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлагыг өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Боловсрол шинжлэх ухааны газрын 2024.07.09-ний өдрийн Б/42 "Урамшуулал олгох тухай" А/42 дугаар тушаалаар "Өөрчлөлтгүй" дүгнэгдсэн Төсвийн шууд захирагч нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох шийдвэрийн дагуу 1,544.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	1,544.0			1	1,544.0		
Нийт дүн	1	1,544.0			1	1,544.0		

-----oOo-----